



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/674

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өөрийн санаачлагаар бүтээсэн иргэнийг онгоцыг Монголын Үндэсний 600 студэд байрлуулах болсон тул тухайн онгоцыг автомашинаар тээвэрлэхэд шаардлагатай шатахууны зардалд 1,500,000 (Нэг сая таван зуун мянган) төгрөгийг Мөрөн сумын иргэн Б.Ширнэндамдинд олгож дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардлын 1.500,000 (Нэг сая, таван зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ